

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС  
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН  
АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА  
(2022 оны жилийн эцсийн байдлаар)**

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2022 онд хамтран ажиллах гэрээний гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, удирдлагыг бодит мэдээлэл, санал зөвлөмжөөр хангахад оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 374 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2022 онд хамтран ажиллах гэрээний гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн**

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2022 онд хамтран ажиллах гэрээг үнэлэхдээ дараах 4 үзүүлэлт тус бүрийн хэрэгжилтийг гаргаж, дундаж үнэлгээгээр гэрээний үүргийн биелэлтийг тооцож гаргасан болно. Үүнд:

1. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээний хэрэгжилт
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт
3. Улсын төсвөөс болон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төсвийн гүйцэтгэл
4. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээний гүйцэтгэл

**3.1 Хамтран ажиллах гэрээний биелэлт**


Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээг 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр байгуулж, гэрээнд 8 чиглэлээр нийт 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан ба Засаг дарга нар гэрээг дунджаар 82.3 хувьтай хэрэгжүүлсэн байна. Энэ нь “тодорхой үр дүнд хүрсэн” буюу зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үг юм. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн

захирагчтай хамтран ажиллах гэрээг Говь-Алтай аймаг хамгийн өндөр буюу 88 хувьтай биелүүлсэн бол Сэлэнгэ, Булган аймгууд хамгийн бага буюу 79.5 хувьтай, бусад аймгууд 80-86 хувьтай хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилтийг үйл ажиллагаа тус бүрээр авч үзвэл:

Хүснэгт 1. Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2022 оны хамтран ажиллах гэрээний заалтын хэрэгжилт (аймгаар)

№	Гэрээг хэрэгжүүлэх чиглэл/аймаг	Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-Алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Сэлэнгэ	Төв	Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Нийслэл	Дундаж
1	Ковид-19 цар тахлаас сэргийлэх, тэмцэх	93.3	88.5	84.0	87.0	92.0	87.5	86.9	88.0	88.0	90.3	88.7	91.2	89.2	88.5	86.0	81.3	89.0	87.0	88.5	85.7	86.7	85.3	87.8
2	НЭМ-ийн ТҮ-ний чиглэлээр	80.0	80.0	82.3	77.0	88.4	81.4	80.1	82.5	80.9	83.9	80.7	83.2	81.0	79.0	79.0	77.8	80.0	79.6	80.0	76.7	79.5	80.7	80.6
3	Анхан шатны ЭМ ТҮ-ний чиглэлээр	86.0	88.2	87.0	79.0	90.0	88.3	86.0	86.0	86.2	85.4	81.0	80.0	88.0	79.0	78.0	80.0	84.8	84.4	86.0	86.0	88.0	83.0	84.6
4	Эх хүүхдийн ЭМ-ийн чиглэлээр	70.2	65.0	73.0	75.0	85.6	70.0	73.0	73.0	75.0	87.1	85.0	86.0	68.0	70.0	68.0	81.1	73.0	71.3	65.6	70.0	73.0	70.6	74.0
5	Аймгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн мэргэжсэн ТҮ-ний	88.2	83.3	89.6	79.6	90.0	89.2	88.3	84.2	83.3	88.3	89.2	84.6	81.7	79.0	87.5	78.2	84.7	86.0	79.5	80.8	85.4	84.2	84.8
6	Эрүүл мэндийн мэдээлэл технологи, цахим шилжилтийн	82.2	81.0	81.8	78.0	84.7	86.0	84.4	81.7	82.0	82.0	79.8	82.9	81.0	79.0	79.8	79.9	80.8	80.3	82.2	80.0	81.3	82.7	81.5
7	Харьяа нутаг дэвсгэрийн ЭМБ-ын хүний нөөцийг дэмжин хөгжүүлэх	86.4	87.6	85.0	80.0	86.0	88.6	82.0	82.0	78.3	85.0	85.7	82.3	78.0	83.4	81.4	78.6	84.3	81.4	83.6	90.0	76.4	81.4	83.1
8	Бусад үйл ажиллагаа	88.0	74.0	84.0	80.0	87.0	85.0	84.0	84.0	82.0	88.0	80.0	81.4	87.4	80.0	80.0	79.0	82.2	76.6	83.0	81.0	78.0	86.0	82.3
	Нийт	84.3	81.0	83.3	79.5	88.0	84.5	83.1	82.7	82.0	86.2	83.7	83.9	81.8	79.7	80.0	79.5	82.3	80.8	81.1	81.3	81.0	81.7	<b>82.3</b>

Зураг 1. Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2022 оны хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн хувь



- Аймаг, нийслэлийн хувьд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан 8 чиглэлээс Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа хамгийн өндөр буюу 87.8 хувьтай хэрэгжсэн байна. Энэ нь эрүүл мэндийн байгууллагууд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, цар тахалтай тэмцэх чиглэлээр мэргэжлийн байгууллагыг оролцуулан эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж, бэлэн байдлыг хангах нөөц бүрдүүлэх, хяналт тавих, цар тахалтай тэмцэх, сэргийлэх мэдээлэх чиглэлээртодорхой хэмжээнд ажиллаж хэвшсэнийг харуулж байна.
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хувьд аймаг бүр эрүүл мэндийг дэмжих цогц, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: “Эрүүл идэвхтэй амьдрал”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хавдрын эсрэг”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл чийрэг эр хүн” болон бусад халдварт, халдварт бус өвчин, орчны эрүүл мэндийн чиглэлээр холбогдох үйл ажиллагааг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж ажилласан байна. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдвар бус өвчин (элэг, хөх, умайн хүзүүний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт зэрэг)-ний эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд иргэн бүрийг хамруулах ажлын хүрээнд 21 аймгийн хувьд 0-17 насны үзлэгт хамрагдвал зохих хүн амын 47.9% нь хамрагдсан бол Улаанбаатарт 39.9% нь хамрагдсан байна. Орхон, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв аймгууд үзлэгт хамрагдвал зохих 0-17 насны хүн амын 50-иас дээш хувийг үзлэг, оношилгоонд хамруулсан бол нийслэл болон бусад аймгууд 31-49 хувьтай хамруулсан байна. Харин 18-аас дээш насны хүн амын үзлэг оношилгооны хамралт харьцангуй бага, орон нутагт 7.9%, Улаанбаатарт 16.1% байна.  
Сүрьеэ өвчнийг илрүүлэх үйл ажиллагааны хүрээнд аймаг, дүүрэгт эрсдэлт бүлгийн хүн амын 96.1%-ийг идэвхтэй илрүүлэгт хамруулж, 391 шинэ тохиолдлын онош баталгаажиж, эмчилгээнд хамруулсан байна. Мөн асуумж судалгаагаар 1334 сүрьеэгийн сэжигтэй тохиолдлыг илрүүлж, харъяа аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт мэдээлж, оношийн баталгаажилт хийгдсэн ба онош батлагдаагүй байна.
- Анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй зохион байгуулах ажлын хүрээнд орон нутгийн болон явуулын иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үүднээс аймаг, сум бүр анхаарч хүн амын шилжилт хөдөлгөөнийг бүртгэж, байнгын болон түр оршин суугчийн бүртгэлийг шинэчлэн хийсэн байна. Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г сумдад зохион байгуулсан байна.
- Эх, хүүхдийн эндэгдэл болон ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулахаар гэрээнд тусгасан ба аймаг, нийслэлийн хувьд энэ чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэг, сургалт, сурталчилгаа, үзлэг, оношилгоо, тандал судалгааны тодорхой ажлуудыг зохион байгуулсан тухай тайлагнасан боловч зарим аймгуудад эхийн эндэгдлийн түвшин буурахгүй байна. Тухайлбал, Баян-Өлгий, Баянхонгор, Дорноговь, Өвөрхангай, Төв, Ховд,

Хөвсгөл аймгуудад сүүлийн 2 жил дараалан 1-3 эх эндсэн байна. Тайлант онд улсын хэмжээнд 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 1.5-аар нэмэгдсэн байна. Эдгээр үзүүлэлт нь эх, хүүхдийн эндэгдэл болон сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээрх үйл ажиллагаа зорилтот түвшиндээ хүрээгүй, цаашид энэ чиглэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

- Аймаг, дүүргийн хүн амд эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг орон нутагт Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Сум, Өрхийн эрүүл мэндийн төв, нийслэлд дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан зохион байгуулж байна. Хамтран ажиллах гэрээнд эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг өргөжүүлэх, халдварын сэргийлэлт, чанар аюулгүй байдал, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний хангамж, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бүрдүүлэлт, хяналтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлыг тайлагнаж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй, хүртээмжтэй байдлыг ханган ажилласан байна.
- Эрүүл мэндийн мэдээлэл технологи, цахим шилжилтийн хүрээнд орон нутагт эмнэлгийн интернэт сүлжээг бүрэн шилэн кабелд шилжүүлж, e-health, e-clinic, e-hospital.mn программыг ашиглаж байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд тус тусдаа хандалтын эрх авч бүрэн ашиглаж байна. Орон нутагт Аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нь интернетэд суурилсан цахим уулзалт, хэлэлцүүлэг, сургалт семинарыг зохион байгуулж хэвшсэн байна. Телемедицинийг ашиглах боломжийг нэмэгдүүлэх үүднээс зарим аймгийн алслагдсан сумдад сүлжээ сайжруулах төхөөрөмж нэмэлтээр суурилуулсан байна. Тухайлбал, Хөвсгөл, Увс, Баянхонгор аймгийн алслагдсан сумдад нэмэлт төхөөрөмжөөр хангах ажил үе шаттайгаар хийгдэж байна.
- Тайлант онд эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг дэмжих чиглэлээр аймгийн Засаг дарга нар идэвх санаачлагатай ажилласныг дурдах хэрэгтэй. Тухайлбал, Сүхбаатар аймгийн Засаг дарын санаачлагаар Түмэнцогт, Асгат сумын эмч нарын байрны асуудлыг шийдвэрлэсэн, Ховд аймгийн Засаг дарга эмч ажилтнуудын байр барихад зориулж 400кв газрын асуудлыг шийдвэрлэсэн, Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн 9 эмч, 19 Сумын ЭМТ-ийн эмнэлгийн ажилтнуудын орон байрны асуудлыг түрээс болон бусад хэлбэрээр шийдвэрлэсэн, Архангай аймагт Хайрхан, Өгийнуур сумын эмч нарыг байраар хангасан, Өвөрхангай аймагт Хархорин суманд эмнэлгийн ажилтны байр барих газрыг шийдвэрлэсэн, Зүүнбаян-Улаан суманд хуучин байрыг засварлан 6 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг байртай болгосон, Сэлэнгэ аймаг 20 эмнэлгийн ажилтанд урьдчилгаа төлбөргүй, хүүгүй орон сууц худалдан авах гэрээ байгуулсан, Баянгол, Жавхлант, Сант, Цагааннуур, Алтанбулаг сумын эрүүл мэндийн төв нь 14 хүний орон байрыг барьж ашиглалтанд оруулсан байна. Мөн аймгууд хүний нөөцийг дэмжих чиглэлээр мөнгөн тусламж, тэтгэмж, сургалтын төлбөр болон бусад төрлийн мөнгөн дэмжлэг туслалцааг үзүүлж ажиллажээ.

### **3.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт**

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас Засаг дарга нартай 2022 онд хамтран ажиллах гэрээний 1 дүгээр хавсралтад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүдийг тусгасан.

2022 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт дунджаар 81.1 хувь буюу 4.1 оноотой үнэлэгдэв. Энэ нь “тодорхой үр дүнд хүрсэн” буюу зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүнд гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үг юм.

Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг Эрүүл мэндийн сайдын 2022 оны Журам шинэчлэн батлах тухай А/346 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3.8-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу, 6.3 дах хэсгийг үндэслэн зарим шалгуур үзүүлэлтийг суурь үзүүлэлт болон улс, аймгийн дундаж үзүүлэлттэй харьцуулах байдлаар үнэлсэн.

**Хүснэгт 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ /хувиар,аймгаар/**

№	Үзүүлэлт	Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-Алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Сэлэнгэ	Төв	Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Нийслэл	Дундаж
1	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	69.0	69.0	90.0	69.0	80.0	100.0	100.0	100.0	69.0	69.0	69.0	90.0	69.0	69.0	69.0	80.0	80.0	69.0	69.0	100.0	80.0	90.0	79.5
2	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	69.0	69.0	75.0	69.0	70.0	100.0	85.0	80.0	80.0	69.0	69.0	69.0	80.0	69.0	90.0	100.0	69.0	80.0	69.0	90.0	80.0	80.0	77.8
3	Хөний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан зорилтот 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо	100.0	100.0	85.0	100.0	100.0	85.0	100.0	85.0	100.0	69.0	70.0	100.0	100.0	70.0	100.0	69.0	75.0	80.0	75.0	100.0	100.0	90.0	88.8
4	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгэнд хамрагдсан зорилтот 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	90.0	100.0	100.0	69.0	69.0	69.0	100.0	69.0	100.0	100.0	30.0	65.1	100.0	46.5	100.0	62.6	82.4	89.5	100.0	100.0	81.3	69.0	81.5
5	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	25.3	26.6	35.8	41.8	41.3	44.1	27.4	39.8	37.8	26.6	38.8	44.2	43.9	24.4	44.1	39.3	41.0	32.3	25.9	32.3	30.9	35.0	35.4
6	В вирус гепатитийн эсрэг тарилгын 24 цагийн хамрагдалтын хувь	95.0	85.0	95.0	85.0	88.0	60.0	75.0	75.0	98.0	90.0	99.0	100.0	70.0	70.0	70.0	100	90.0	90.0	80.0	80.0	90.0	75.0	84.5
7	Тавт /сажу татран.тм/ сэргийлэх тарилгын хамралтын хувь 3-р түн	100.0	95.0	98.3	97.6	100.0	100.0	98.5	98.2	98.5	96.7	97.4	98.5	100.0	100.0	99.0	100.0	99.5	99.0	98.2	95.0	97.8	100.0	98.5
8	Улаанбурхан-гахайн хавдар- улаанууд тарилгын хамралтын хувь	100.0	90.0	100.0	100.0	100.0	100.0	99.4	100.0	95.2	96.4	97.6	99.0	100.0	91.3	98.5	96.2	99.5	98.0	97.0	94.0	97.6	100.0	97.7
9	Эхийн эндэгдлийн түвшин /10000 амьд төрөлтөд/	100.0	10.0	20.0	100.0	100.0	100.0	100.0	20.0	100.0	100.0	100.0	100.0	20.0	100.0	20.0	100.0	20.0	100.0	10.0	0	20.0	30.0	62.3
10	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	30.0	70.0	50.0	50.0	70.0	10	50.0	50.0	50.0	70.0	80.0	90.0	30.0	30.0	30.0	50.0	30.0	30.0	80.0	30.0	30.0	50.0	48.2
11	Нярайн эндэгдэл (1000 амьд төрөлтөд)	30.0	70.0	50.0	50.0	70.0	30	50.0	50.0	50.0	70.0	80.0	80.0	30.0	30.0	30.0	50.0	30.0	30.0	80.0	30.0	30.0	50.0	48.6
12	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	30.0	30.0	50.0	30	70.0	10	30.0	30.0	30.0	70.0	90.0	90.0	30.0	20.0	20.0	60.0	30.0	30.0	80.0	70.0	30.0	50.0	44.5
13	Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд)	50.0	45.0	70.0	69.0	75.0	30.0	69.0	80.0	45.0	50.0	75.0	69.0	69.0	75.0	70.0	50.0	30.0	45.0	70.0	69.0	69.0	50.0	60.2
14	Жирэмсний эхний 3 сард хяналтанд орсон эх	90.0	85.0	95.0	100.0	85.0	90.0	100.0	90.0	100.0	100.0	85.0	100.0	100.0	85.0	85.0	85.0	100.0	90.0	90.0	85.0	90.0	95.0	92.0
15	Эсвэр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин	90.0	85.0	30.0	80.0	70.0	90.0	69.0	82.0	50.0	45.0	90.0	40.0	40.0	40.0	30.0	80.0	85.0	83.0	70.0	45.0	30.0	40.0	62.0
16	Сурьсэгийн өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	90.0	100.0	75.0	100.0	80.0	100.0	60.0	70.0	70.0	100.0	80.0	70.0	80.0	100.0	100.0	70.0	70.0	70.0	100.0	80.0	70.0	69.0	82.0
17	Вирүст гепатитын өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	95.0	85.0	95.0	85.0	88.0	60.0	75.0	75.0	98.0	90.0	99.0	100.0	70.0	70.0	70.0	90	90.0	90.0	80.0	80.0	90.0	75.0	84.1
18	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	69.0	50.0	80.0	40.0	69.0	85.0	70.0	85.0	90.0	69.0	98.0	69.0	69.0	80.0	80.0	69.0	69.0	80.0	80.0	60.0	80.0	80.0	73.7
19	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	80.0	92.0	82.0	70.0	70.0	82.0	69.0	72.0	69.0	75.0	75.0	75.0	80.0	90.0	70.0	83.0	85.0	70.0	82.0	70.0	85.0	75.0	77.3
20	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин, 10 000 хүн амд	83.0	90.0	69.0	72.0	72.0	90.0	88.0	65.0	81.0	74.0	85.0	76.0	84.0	40.0	86.0	83.0	81.0	67.0	88.0	50.0	69.0	76.0	75.9
21	Санамсаргүй хордох хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд (Х40-Х49)	75.0	85.0	80.0	80.0	78.0	60.0	80.0	58.0	82.0	84.0	83.0	69.0	80.0	80.0	90.0	80.0	69.0	80.0	90.0	75.0	80.0	50.0	76.7
22	0-5 насны хүүхдийн түлэгдэлт хувь	80.0	100.0	100.0	100.0	80.0	100.0	100.0	90.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	90.0	80.0	100.0	100.0	100.0	80.0	70.0	94.1
23	Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин /10 000 хүүхдэд/	69.0	90.0	60.0	80.0	60.0	77.0	90.0	55.0	87.0	69.0	73.0	90.0	80.0	73.0	73.0	80.0	69.0	80.0	80.0	85.0	85.0	85.0	76.8
	Дундаж	74.3	74.9	73.3	75.5	77.6	72.7	77.6	70.4	77.4	77.5	81.0	81.9	70.6	67.5	70.6	70.3	68.5	73.2	78.0	70.4	69.4	68.9	

### 3.2.1 Урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг

**Хүснэгт 3. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдсан хүн амын тоо, эзлэх хувь, /хүүхэд, насанд хүрэгчид, аймгаар/**

Аймаг	0-17 нас			18-дээш нас		
	Хамрагдвал зохих хүн ам	Хамрагдсан хүн ам	Хамрагдалтын хувь	Хамрагдвал зохих хүн ам	Хамрагдсан хүн ам	Хамрагдалтын хувь
Архангай	34501	12012	34.8	61366	3469	5.7
Баян-Өлгий	44321	14760	33.3	64055	5939	9.3
Баянхонгор	33608	16743	49.8	56367	4204	7.5
Булган	21020	12620	60	40918	2830	6.9
Говь-Алтай	21015	11090	52.8	37720	4997	13.2
Говьсүмбэр	7162	3882	54.2	10991	1788	16.3
Дархан-Уул	37619	13503	35.9	67118	5397	8
Дорноговь	26289	13888	52.8	45824	5013	10.9
Дорнод	31505	17052	54.1	53070	3329	6.3
Дундговь	16752	5233	31.2	30790	3484	11.3
Завхан	26254	12872	49	47548	6219	13.1
Орхон	37472	23832	63.6	68673	4877	7.1
Өвөрхангай	42676	25558	59.9	74585	7725	10.4
Өмнөговь	27157	8784	32.3	45786	3077	6.7
Сүхбаатар	23845	14274	59.9	41383	4370	10.6
Сэлэнгэ	38214	22409	58.6	70673	2948	4.2
Төв	33513	20488	61.1	60529	2723	4.5
Увс	33433	15169	45.4	51881	3254	6.3
Ховд	35323	12111	34.3	55010	3988	7.2
Хөвсгөл	50071	23421	46.8	87557	4308	4.9
Хэнтий	28741	11716	40.8	50688	4341	8.6
Аймгийн дүн	650491	311417	47.9	1122532	88280	7.9
Улаанбаатарын дүн	565540	225483	39.9	973712	156585	16.1
Улсын дүн	1216031	536900	44.2	2096244	244865	11.7

Тайлант онд орон нутагт урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд 0-17 насны үзлэгт хамрагдвал зохих хүн амын 47.9% нь хамрагдсан бол Улаанбаатарт 39.9% нь хамрагдсан байна. Орхон, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв аймгууд үзлэгт хамрагдвал зохих 0-17 насны хүн амын 50-иас дээш хувийг үзлэг, оношилгоонд хамруулсан бол нийслэл болон бусад аймгууд 31-49 хувьтай хамруулсан байна. Харин 18-аас дээш насны хүн амын үзлэг оношилгооны хамралт харьцангуй бага, орон нутагт 7.9%, Улаанбаатарт 16.1% байна.

**3.2.2 Эх, хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой үзүүлэлтүүд**

### 1.Эхийн эндэгдлийн түвшин

Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар эхийн эндэгдлийн 23 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 35.1 ногдож байгаа бол орон нутагт 42.8 байна. 2021 оны хувьд коронавируст халдварын улмаас улсын хэмжээнд 68 эх эндсэн ба энэ нь өмнөх оноос 3.1 дахин буюу эрс нэмэгдсэн үзүүлэлттэй байсан. Харин 2022 оны эхийн эндэгдлийн түвшинг өмнөх онтой харьцуулахад 2.7 дахин буурсан харагдаж байгаа ч КОВИД-ын өмнөх үетэй харьцуулахад 4.9 пунктээр нэмэгдсэн байна.

#### *Хүснэгт 4. Эхийн эндэгдэл, 2021-2022 оны жилийн эцсийн байдлаар (100 000 амьд төрөлтөд аймгаар)*

Аймаг/ хот	2021 онд	2022 онд
1. Архангай	242.4	0
2. Баян-Өлгий	68.3	72.1
3. Баянхонгор	53.8	59.6
4. Булган	0	0
5. Говь-Алтай	0	0
6. Говьсүмбэр	0	0
7. Дархан-Уул	136.7	0
8. Дорноговь	68.6	80
9. Дорнод	167.6	0
10. Дундговь	0	0
11. Завхан	75.2	0
12. Орхон	39.7	0
13. Өвөрхангай	45.3	50.3
14. Өмнөговь	0	0
15. Сүхбаатар	0	90.1
16. Сэлэнгэ	123.2	0
17. Төв	177.1	125
18. Увс	0	0
19. Ховд	147.4	110.8
20. Хөвсгөл	37.7	130.5
21. Хэнтий	0	77
<b>Аймгийн дүн</b>	<b>70.9</b>	<b>42.8</b>
22. Улаанбаатар	118.1	28.4
<b>Улсын дүн</b>	<b>94.9</b>	<b>35.1</b>

Зарим аймгуудад эхийн эндэгдлийн түвшин буурахгүй байгаа ба тухайлбал, Баян-Өлгий, Баянхонгор, Дорноговь, Өвөрхангай, Төв, Ховд, Хөвсгөл аймгуудад сүүлийн 2 жил дараалан 1-3 эх эндсэн бол Архангай, Дархан-Уул, Дорнод, Завхан, Орхон, Сэлэнгэ аймгууд эхийн эндэгдлийг өнгөрсөн оноос бууруулж эндэгдэлгүй ажилласан байна. Харин Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь, Увс аймгууд сүүлийн 2 жилд эхийн эндэгдэлгүй ажилласан байна.

Нийслэлд 2021 онд 43 эх эндсэн бол 2022 онд 10 эх эндсэн ба өнгөрсөн онтой харьцуулахад 4.1 дахин буурсан харагдаж байгаа ч үүнийг КОВИД-ын өмнөх үетэй харьцуулахад ижил түвшинд байна.

### 2. Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин

Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар нялхсын эндэгдлийн 814 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 12.4 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.8-аар буурсан үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдлийн 62.7 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа ба 1000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл 7.8 байна. Нярайн эндэгдлийн нийт 510 тохиолдлын 365 буюу 71.6 хувь нь эрт үеийн эндэгдэл, 145 буюу 28.4 хувийг хожуу үеийн эндэгдэл тус тус эзэлж байна.

Харин 2022 онд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 1019 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 15.5 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6-аар өссөн байна. Нийт тохиолдлын 24.5 хувь нь эмнэлгээс гадуур, 75.5 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс хоног болоогүй нас баралт 29.5 хувийг эзэлж байна. Шалтгаанаар авч үзвэл нийт эндэгдлийн 87.6 хувь нь өвчнөөр, 12.4 хувь нь осол, гэмтлийн улмаас эндсэн байна.

#### Хүснэгт 5. Нялхсын эндэгдэл (1000 амьд төрөлтөд, аймгаар)

Аймаг/ хот	Нялхсын эндэгдэл / 1000 амьд төрөлтөд/			5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл / 1000 амьд төрөлтөд/		
	2021	2022	Зөрүү	2021	2022	Зөрүү
1. Архангай	9.7	13.5	3.8	13.3	18.7	5.4
2. Баян-Өлгий	16.4	14.4	-2	18.4	20.9	2.5
3. Баянхонгор	8.6	9.5	0.9	11.3	12.5	1.2
4. Булган	14.3	14.7	0.4	14.3	22.1	7.8
5. Говь-Алтай	17.7	13.4	-4.3	21.6	20.1	-1.5
6. Говьсүмбэр	2.1	10.6	8.5	2.1	13.2	11.1
7. Дархан-Уул	9.6	10.5	0.9	10.9	13.5	2.6
8. Дорноговь	8.9	9.6	0.7	12.3	13.6	1.3
9. Дорнод	7.8	8.2	0.4	10.1	12	1.9
10. Дундговь	14	11.8	-2.2	15.2	11.8	-3.4
11. Завхан	19.5	11.9	-7.6	24.8	16.4	-8.4
12. Орхон	12.3	6.5	-5.8	13.9	6.9	-7
13. Өвөрхангай	10.9	14.6	3.7	13.1	16.6	3.5
14. Өмнөговь	11	15.1	4.1	12.2	17.5	5.3
15. Сүхбаатар	5.1	8.1	3	5.8	11.7	5.9
16. Сэлэнгэ	10.5	9.7	-0.8	14.8	15.7	0.9
17. Төв	15.1	21.3	6.2	21.3	30	8.7
18. Увс	10.2	13.7	3.5	11.8	18.5	6.7
19. Ховд	18.2	15.5	-2.7	21.1	20.5	-0.6
20. Хөвсгөл	13.6	16.1	2.5	18.1	17.8	-0.3
21. Хэнтий	9.8	12.3	2.5	13.1	16.2	3.1
<b>Аймгийн дүн</b>	<b>12</b>	<b>12.3</b>	<b>0.3</b>	<b>14.7</b>	<b>16.2</b>	<b>1.5</b>
22. Улаанбаатар	11.1	12.4	1.3	13.1	14.7	1.6
<b>Улсын дүн</b>	<b>11.6</b>	<b>12.4</b>	<b>0.8</b>	<b>13.9</b>	<b>15.5</b>	<b>1.6</b>

### 3.2.3 Эмнэлгийн тусламж үйлчилгээний бусад үзүүлэлтүүд



*Нас баралт.* 2022 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нас баралтын 17 981 тохиолдол бүртгэгдсэн ба нас баралтын түвшин 10 000 хүн амд 53.1 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.8-аар буурсан боловч КОВИД-ын өмнөх үетэй харьцуулахад 0.5-аар нэмэгдсэн байна. Нийт нас баралтын 29.6 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс 1295 тохиолдол буюу 24.3 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна. Эмнэлэгт хоног болоогүй нас баралт өмнөх оны мөн үеэс 10 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 3346 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 10.2 байна. Энэ нь өнгөрсөн оноос 0.8-аар, 2019-2020 оны түвшнээс 1,5-аар нэмэгдсэн байна.

*Эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд.* Тайлант онд улсын хэмжээнд эмнэлгийн орны фонд ашиглалт 66.3 хувь, аймгийн дундаж 64.7 хувь, Улаанбаатарт 67.8 хувьтай байна. Энэ нь өнгөрсөн оноос улсын дундаж 4.6 хувиар, орон нутагт 12.3 хувиар, Улаанбаатарт 2,9 хувиар нэмэгдсэн боловч хангалтгүй байгааг харуулж байна.

#### *Хүснэгт 6. Эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд*


№	Аймаг/хот	Орны тоо	Орны фонд ашиглалт	Орны фонд ашиглалтын хувь	Дундаж ор хоног	Орны эргэлт
1	Архангай	551	245.5	67.3	6.9	35.9
2	Баян-Өлгий	946	227.6	62.4	6.8	33.6
3	Баянхонгор	667	275.4	75.4	7	39.6
4	Булган	297	272.4	74.6	7.3	38.2
5	Говь-Алтай	491	210.3	57.6	7.3	29.1
6	Говьсүмбэр	149	285.8	78.3	7.1	40.6
7	Дархан-Уул	784	281.7	77.2	7	41
8	Дорноговь	540	254.8	69.8	7.1	36.4
9	Дорнод	573	243.6	66.7	7.2	34.5
10	Дундговь	351	226.7	62.1	7.5	30.5
11	Завхан	757	182.4	50	7	26.3
12	Орхон	900	282.3	77.3	6.6	42.8
13	Өвөрхангай	966	203	55.6	7	29.6
14	Өмнөговь	696	178.7	49	6.7	26.9
15	Сүхбаатар	548	223.4	61.2	8	28.3
16	Сэлэнгэ	830	209.6	57.4	7.3	29.1
17	Төв	572	218.5	59.9	7.4	30.3
18	Увс	575	265.4	72.7	6.7	40.1
19	Ховд	826	260.3	71.3	7.5	34.9
20	Хөвсгөл	922	220.4	60.4	6.8	33.1
21	Хэнтий	622	252.8	69.3	7.5	34
22	<b>Аймгийн дүн</b>	<b>13563</b>	<b>236</b>	<b>64.7</b>	<b>7.1</b>	<b>33.8</b>
23	Улаанбаатар	15326	247.3	67.8	6.7	37.4
24	<b>Улсын дүн</b>	<b>28889</b>	<b>242</b>	<b>66.3</b>	<b>6.9</b>	<b>35.7</b>

### **3.3 Төсөв, санхүүжилт**

Эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн шинэчлэлийг 2021 оноос хэрэгжүүлж, эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн тусламж, үйлчилгээг гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлэхээр хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг 2021 оны 3 дугаар сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн. 2022 онд ЭМДЕГ нь төрийн өмчийн 78 эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн 193 эрүүл мэндийн байгууллага, 54 сувилал, 532 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, 1520 эмийн сан, нийт 2377 байгууллагатай гэрээ байгуулан тусламж үйлчилгээг нийт 1,745.7 тэрбум төгрөгөөр худалдан авсан байна.

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын ЭМД-ын санхүүжилт өнгөрсөн оноос 69,7 тэрбум төгрөг буюу 55.7%-иар нэмэгдсэн бол орон нутгийн хувьд Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн санхүүжилт хамгийн ихээр буюу өнгөрсөн оноос 4.6 тэрбум төгрөг (48%)-өөр нэмэгдсэн бол, Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлгийн санхүүжилт хамгийн бага буюу 36.3 сая төгрөг (0,4%)-өөр нэмэгдсэн байна. Орон нутагт Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Хэнтий зэрэг 10 аймгийн нэгдсэн эмнэлгүүд нийт 8.2 тэрбум төгрөгийн өглөгтэй, Нийслэлд Баянгол, Сүхбаатар дүүргийн эмнэлгүүд 2.2 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан байна. Энэ нь эмнэлгүүдэд ЭМД-ын сангаас олгох санхүүжилт хугацаа хоцорч буюу оны төгсгөлд шийдвэрлэгдсэнтэй холбоотой эмнэлгүүд тогтмол зардал болох цэвэр бохир ус, халаалт, эм, эмнэлгийн хэрэгсэл болон бусад зардлын өглөгийг шилжүүлж чадалгүй он дуусгасантай холбоотой байна. Нийслэлд Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв нь 2022 оны төгсгөлд буюу 11 дүгээр сард тус төвийн 1, 2, 3, 4 давхарын засварын ажил болон компьютер, принтер дагалдах хэрэгсэлийг худалдан авах, 12 дугаар сард компьютер томографийн аппарат худалдан авах тендерийг тус тус зарласан ба 2022 онд санхүүжих мөнгөн дүнг нийлүүлэгчид шилжүүлж амжаагүй он дууссан тул 2.2 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан байна. Гэвч он гарч, санхүүжилтийн эрх нээгдснээр эдгээр өглөгүүдийг бүрэн шийдвэрлэсэн байна.

Зураг 2. Аймаг, дүүргийн эмнэлгүүдийн өглөг.(2022 оны жилийн эцсийн байдлаар)




Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас Засаг дарга нартай 2022 онд хамтран ажиллах гэрээнд улсын төсвөөс санхүүждэг Эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төвүүдийн төсвийг гэрээний хавсралтаар баталдаг ба бусад эрүүл мэндийн байгууллагууд болох Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Сумын эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төв, Рашаан сувилалын газрууд нь Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгэлээр санхүүжилт авч ажиллаж байна.

### 3.4 Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээний гүйцэтгэл

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2022 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн дундаж дүн 75.8 хувьтай байна.

*Зураг 3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэл /хувиар, аймаг, нийслэлээр/*



Эрүүл мэндийн сайд нь Төсвийн тухай хуулийн 14.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.3 дахь заалтыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгүүлсэн байна. Хамтран ажиллах гэрээнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг бүрэн гүйцэтгэж ашиглалтад оруулсан Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Сүхбаатар аймгууд байгаа бол Өмнөговь, Хөвсгөл аймгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 60 хувь буюу хамгийн

бага гүйцэтгэлтэй байна. Харин Орхон аймагт 2022 онд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ батлагдаагүй байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.5 заалтыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын "Эрх шилжүүлэх тухай" тушаалуудын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга нарт худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлж, 6.7 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад нийлүүлж, санхүүжилтийг олгосон байна.

### 3.5 Нэгдсэн үнэлгээ

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2022 онд хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийн дундаж 80.7 хувьтай буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдсэн ба үзүүлэлт тус бүрээр харуулбал:

1. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээний хэрэгжилт 82.7 хувь
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт 81.1 хувь
3. Улсын төсвөөс болон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төсвийн гүйцэтгэл 83.6 хувь
4. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээний гүйцэтгэл 75.8 хувь

#### Хүснэгт 7. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2022 онд хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлт

№	Аймгийн нэр	ЭМТҮ-ний чанарын үзүүлэлтийн биелэлт		Төсөв		Хөрөнгө оруулалт		ЗД гэрээний хэрэгжилт		Үнэлгээ	
		Хувь	Оноо	Хувь	Оноо	Хувь	Оноо	Хувь	Оноо	Хувь	Оноо
1	Архангай	81.2	4.1	90.0	4.5	67.5	3.4	84.3	4.2	80.7	4.0
2	Баян-Өлгий	78.1	3.9	80.0	4.0	72	3.6	81.0	4.0	77.8	3.9
3	Баянхонгор	81.4	4.1	95.0	4.8	70	3.5	83.4	4.2	82.4	4.1
4	Булган	80.5	4.0	80.0	4.0	80	4.0	79.5	4.0	80.0	4.0
5	Говь-Алтай	87.0	4.4	88.0	4.4	80	4.0	88.0	4.4	85.8	4.3
6	Говьсүмбэр	81.9	4.1	88.0	4.4	100	5.0	84.5	4.2	84.8	4.2
7	Дархан-Уул	84.9	4.2	85.0	4.3	100	5.0	82.9	4.1	88.2	4.4
8	Дорноговь	80.7	4.0	75.0	3.8	68.5	3.4	82.7	4.1	76.7	3.8
9	Дорнод	83.6	4.2	75.0	3.8	75	3.8	82.0	4.1	78.9	3.9
10	Дундговь	81.4	4.1	80.0	4.0	100	5.0	86.3	4.3	86.9	4.3
11	Завхан	79.8	4.0	85.0	4.3	65	3.3	83.8	4.2	78.4	3.9
12	Орхон	81.7	4.1	87.0	4.4	***	***	83.9	4.2	84.2	4.2
13	Өвөрхангай	79.6	4.0	75.0	3.8	65	3.3	81.8	4.1	75.3	3.8
14	Өмнөговь	76.7	3.8	75.0	3.8	61.1	3.1	80.0	4.0	73.2	3.7
15	Сүхбаатар	81.0	4.0	90.0	4.5	95	4.8	80.0	4.0	86.5	4.3
16	Сэлэнгэ	79.2	4.0	80.0	4.0	70	3.5	79.4	4.0	77.1	3.9
17	Төв	78.8	3.9	80.0	4.0	73.7	3.7	82.4	4.1	78.7	3.9
18	Увс	81.5	4.1	90.0	4.5	80	4.0	84.0	4.2	83.9	4.2
19	Ховд	80.9	4.0	94.0	4.7	75	3.8	85.0	4.3	83.7	4.2
20	Хөвсгөл	81.5	4.1	92.0	4.6	60.5	3.0	82.0	4.1	79.0	4.0
21	Хэнтий	82.2	4.1	75.0	3.8	62.4	3.1	81.0	4.1	75.2	3.8
22	Нийслэл	80.2	4.0	80.0	4.0	71	3.6	82.7	4.1	78.5	3.9
	Дундаж	81.1		83.6		75.8		82.7		80.7	

## Дөрөв. Дүгнэлт

- Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан 2022 онд хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийг 80.7 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэлээ.
- Иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах ажил орон нутагт 0-17 насны үзлэгт хамрагдвал зохих хүн амын 47.9% нь хамрагдсан бол Улаанбаатарт 39.9% нь хамрагдсан байна. Харин 18-аас дээш насны хүн амын үзлэг оношилгооны хамралт харьцангуй бага, орон нутагт 7.9%, Улаанбаатарт 16.1% байна.
- Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар эхийн эндэгдлийн 23 тохиолдол бүртгэгдэж, 100 000 амьд төрөлтөд 35.1 ногдож байгаа бол орон нутагт 42.8 байна. 2021 оны хувьд коронавируст халдварын улмаас эхийн эндэгдэл нэмэгдсэн үзүүлэлттэй байсан бол тайлант оны эхийн эндэгдлийн түвшинг өмнөх онтой харьцуулахад 2.7 дахин буурсан харагдаж байгаа ч КОВИД-ын өмнөх үетэй харьцуулахад 4.9-өөр нэмэгдсэн байна. Энэ нь эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр орон нутгийн түвшинд тодорхой ажлуудыг зохион байгуулж байгаа ч эхийн эндэгдлийн түвшин тууштай буурахгүй байна.
- 10 аймагт амьгүй төрөлтийн түвшин аймгийн дунджаас дээгүүр байгаа нь жирэмсний хяналтын үйл ажиллагааг чанаржуулах шаардлагатай байгааг, 10 аймагт 1000 эмэгтэйд ноогдох үр хөндөлтийн түвшин аймгийн дунджаас дээгүүр байгаа нь жирэмснээс сэргийлэх арга хэрэгслийг сурталчилах, өсвөр насны хүүхдэд эрүүл мэндийн боловсролыг олгох асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.
- Олон улсын түвшинд орны фонд ашиглалтын хамгийн тохиромжтой хэмжээг 80-85% хувь гэж үздэг ба 85-аас бол эмнэлгээс шалтгаалсан халдвар гарах эрсдэлийг нэмэгдүүлдэг бол 80-аас бага байх нь эмнэлгийн орны зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатайг харуулдаг байна. 2022 онд улсын хэмжээнд эмнэлгийн орны фонд ашиглалт 66.3 хувь, аймгийн дундаж 64.7 хувь, Улаанбаатарт 67.8 хувьтай байна. Энэ нь өнгөрсөн оноос улсын дундаж 4.6 хувиар, орон нутагт 12.3 хувиар, Улаанбаатарт 2.9 хувиар нэмэгдсэн боловч хангалтгүй байгааг харуулж байна.
- Хүн амын дунд осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын түвшин 10000 хүн амд 10.2 ногдож байгаа нь өнгөрсөн оноос 0.8-аар, 2019-2020 оны түвшнээс 1,5-аар нэмэгдсэн байна.
- Амиа хорлож нас барсан 10000 хүн амд ноогдох үзүүлэлтээр Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Орхон, Увс, Хөвсгөл, Хэнтий аймгууд аймгийн дунджаас дээгүүр байна.
- Сүрьеэтэй өвчнийг илрүүлэн оношлох, эмчлэх нь сүрьеэг устгах хамгийн чухал арга зам хэвээр байсаар байгаа. Уг үйл ажиллагааны хүрээнд аймаг, дүүрэгт эрсдэлт бүлгийн хүн амын 96.1%-ийг идэвхтэй илрүүлэгт хамруулж, шинэ тохиолдлын оношийг баталгаажуулж, эмчилгээнд цаг алдалгүй хамруулж байгаа нь сайшаалтай байна.

- Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээний 3 дугаар хавсралтаар батлагдсан эрүүл мэндийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт 75.8 хувьтай буюу өнгөрсөн оноос 4.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2021 онд Коронавируст халдварын цар тахлын үед хил, гаалийн хорио цээр болон үе шаттай хэрэгжүүлсэн өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд барилга угсралтын ажил хэвийн явагдаж чадаагүй мөн барилгын бараа материалын үнийн өсөлттэй холбоотойгоор төлөвлөсөн барилгууд цаг хугацаандаа ашиглалтад орох боломжгүйгээс барилгын ажлын гүйцэтгэл 71% байсан бол 2022 онд 75.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь удаашралтай байгааг харуулж байна.

### **Тав. Зөвлөмж**

- ❖ Эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр. Орон нутаг болон нийслэлд эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр дараах үйл ажиллагааг хамруулсан, цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх. Үүнд:
  1. Эхийн эндэгдлийн түвшин буурахгүй байгаа Баян-Өлгий, Баянхонгор, Дорноговь, Өвөрхангай, Төв, Ховд, Хөвсгөл аймгууд болон нийслэлд эндэгдлийг бууруулах чиглэлийн тодорхой үйл ажиллагаа
  2. Улсын хэмжээнд жирэмсний эрт хяналт ба тогтмол хяналтын үйл ажиллагааг чанаржуулах, аливаа эмгэгийг эрт үед нь илрүүлэх, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах
  3. Өсвөр насны хүүхдүүдэд бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, жирэмснээс хамгаалах арга хэрэгслийг таниулах, сурталчилах, эрүүл мэндийн боловсрол олгох
  4. Архангай, Баянхонгор, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Хөвсгөл, Хэнтий аймгууд болон нийслэлд нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг тууштай бууруулах арга хэмжээ
- ❖ Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр. Эмнэлгийн орны фонд ашиглалтын хувь, орны эргэлт зэрэг үзүүлэлтээс харахад эмнэлгийн орны төлөвлөлтийг боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна. Тухайн орон нутгийн онцлог, хүн амын нягтаршил, алслагдсан байдал, хүний нөөцийн чадамж, өвчний чиг хандлага зэрэг оолон үзүүлэлтэд тулгуурлан эргэн харах
- ❖ Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний илрүүлэг шинжилгээ болон улсын хэмжээнд зохион байгуулж байгаа эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд 18-аас дээш насны хамрагдвал зохих иргэдийг бүрэн хамруулж, өвчлөл илэрсэн тохиолдлыг эмнэлгийн хяналтад авч хяналт тавьж ажиллах
- ❖ Орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, Засаг даргын нөөц хөрөнгөөс эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд зарцуулсан санхүүжилтийн мөнгөн дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар тодорхой, тоо баримттай тайлагнах

- ❖ Тайлант оны гэрээний хэрэгжилтийн үнэлгээнээс дүгнэхэд гэрээний хавсралт дахь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна. Иймд гэрээнд дараах өөрчлөлтийг оруулах:
  1. Гэрээний 1-р хавсралт дахь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын зарим үзүүлэлтийг нэгтгэх, үнэлгээнд ач холбогдол багатай зарим үзүүлэлтийг хасах, шаардлагатай зарим үзүүлэлтийг нэмэх, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын 3.8-р хавсралттай уялдуулах гэх мэт холбогдох өөрчлөлт оруулах
  2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2023 оны хамтран ажиллах гэрээний 6-р зүйл дэх Гэрээний хэрэгжилтийг үнэлэх хэсэгт Гэрээг хэрэгжүүлэгчийн үүрэгт тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилт гэсэн үзүүлэлтийг нэмэх
  3. Үнэлгээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн эзлэх хувийг нэмэх
- ❖ Орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, Засаг даргын нөөц хөрөнгөөс эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд зарцуулсан санхүүжилтийн мөнгөн дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар тодорхой, тоо баримттай тайлагнах
- ❖ Хамтран ажиллах гэрээнд тусгагдсан, эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах
- ❖ Эрүүл мэндийн байгууллагуудад цахим мэдээллийн технологи ашиглах, түүний тогтвортой ажиллагааг хангах
- ❖ Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хагас, бүтэн жилээр цахим хэлбэрээр цаг хугацаанд нь ирүүлж хэвших

Эрүүл мэндийн яам  
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ  
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ШИЙДВЭР


2023 оны 03 дугаар сарын 01

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх үүднээс Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан 2022 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан 2022 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг 80.7 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үзсүгэй
2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг танилцуулгын хамт 2023 оны 3 дугаар сарын 01-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх; Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд үнэлгээний дүнг байршуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт үүрэг болгосугай
3. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2023 оны хамтран ажиллах гэрээний 6-р зүйл дэх Гэрээний хэрэгжилтийг үнэлэх хэсэг болон 1-р хавсралт дахь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтэд үнэлгээний зөвлөмжид тусгагдсаны дагуу нэмэлт өөрчлөлт оруулж, 04 дүгээр сарын 15-ны дотор баталгаажуулахыг Бодлого, төлөвлөлтийн газарт үүрэг болгосугай

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  С.ТӨГСДЭЛГЭР





**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41  
И-мэйл: letter@moh.gov.mn, http://moh.gov.mn

2023.03.01 № 1a/852  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА  
Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Тайлан хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Эрүүл мэндийн яамны 2022 оны үйл ажиллагаа болон Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай 2022 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Дараах тайлан, танилцуулга, хурлын шийдвэрийг хавсаргав. Үүнд:

1. Эрүүл мэндийн яамны 2022 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга - 13 хуудас;
2. Эрүүл мэндийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, танилцуулга, Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр - 190 хуудас;
3. Яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ - 2 хуудас;
4. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн үнэлгээний тайлан - 5 хуудас;
5. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээний тайлан - 26 хуудас;
6. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай 2022 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, танилцуулга - 15 хуудас;
2. Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр - 2 хуудас.

Хавсралт нийт 23 хуудастай.



С.ЧИНЗОРИГ

141423918





МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41  
И-мэйл: letter@moh.gov.mn, http://moh.gov.mn

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН  
ЗАСАГ ДАРГА НАРТ

2023.03.03 № 1a/895  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Үнэлгээний тайлан хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2022 оны хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолын дагуу хяналт үнэлгээ хийж гүйцэтгэлээ. Үнэлгээний дүнг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд зүйл заалт тус бүрээр оруулсан тул үнэлгээний дэлгэрэнгүтэй <http://new.unelgee.gov.mn>-аас танилцана уу. Үнэлгээний танилцуулгыг үүгээр хүргүүлж байгаа ба зөвлөмжийн дагуу холбогдох чиглэлээр цогц арга хэмжээ авч, хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт хуудас



С.ЧИНЗОРИГ

141423346